



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

“Тахько” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 32.4, 31.2.1, “Тахько” ХК-ийн 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тахько” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 808,842 /найман зуун найман мянга найман зуун дөчин хоёр/ ширхэг хувьцаа болон нэг бүр нь 236 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 381,141 /гурван зуун наян нэгэн мянга нэг зуун дөчин нэг/ ширхэг энгийн хувьцааг тус тус нэг бүрийг нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,189,983 /нэг сая нэг зуун наян есөн мянга есөн зуун наян гурав/ ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлж үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Тахько” ХК /Л.Буянбат/-д үүрэг болгосугай:


1/ Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу өөрчилж, санхүүгийн тайланд холбогдох хууль, тогтоомжийн дагуу өөрчлөлт оруулах;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Энэхүү тогтоолын 1, 2-т заасан өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд 2012 оны 6 дугаар сарын 29-ний дотор ирүүлэх;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН